

Монголд Цанид, Чойрын сургалт үүсэж хөгжсөн түүхийг үечлэх асуудалд

М.Отгонбаяр доктор (Ph.D), профессор
МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхим
С.Янжинсүрэн доктор (Ph.D) гэрээт профессор
МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхим
Н.Мөнхцэцэг, докторант

Түлхүүр үг: Монголын гүн ухаан, цанид, чойрийн сургалт, мэтгэлцээн.
Наландар

Хураангуй: Монголын түүхэнд бурхны шашин гурвантаа дэлгэрсэн бөгөөд хожуу дэлгэрэлтийн үед бурхны шашин хөгжлийн өндөр түвшинд хүрч “Монголын буддизм” гэх тодотголыг буй болгосон нь буддын их таван ухааны нэг болох “учир шалтгааны ухаан” үүсэж хөгжсөнтэй салшгүй холбоотой. “Учир шалтгааны ухаан” хэмээх нэрийн дор Энэтхэгийн мэргэд гүн ухаан, сэтгэл судлал, логик-эпистемологи зэрэг салбарын нөлөө бүхий онолыг боловсруулжээ. Тэдгээр сэтгэгчдийн баталсан онолын хүрээнд Төвөдийн сэтгэгчид дүн шинжилгээ хийх мэтгэлцээний аргазүйг боловсруулжээ. Энэ нь аргазүйгээр боловсорсон Монгол мэргэд буддын гүн ухааны гүнзгий ойлголт, асуудлуудыг тал бүрээс нь судлан олон боть сүмбум бүтээсэн нь учир шалтгааны ухаан нэн дэлгэр хөгжиж байсан нэгэн баримт болно. Өнөөдрийг хүртэл энэ нь Төвөд, Монголын цанид чойрын сургуулиудын боловсролын бүтцийн нэг хэсэг нь байсаар ирсэн бөгөөд буддын гүн ухааныг ойлгох түлхүүрүүдийн нэг юм. Монголын бурхны шашны түүхэнд үечлэл хийсэн эрдэмтэд нэлээдгүй байгаа ч, цанид, чойрын түүхийг тухайлан судалсан нь ховор байна. Эл сэдвийг түүхэн сурвалжийн мэдээнд тулгуурлан үечилж авч үзсэн болно.

Эртний Энэтхэгт Будда Шагжамуни шавь нартаа ном сургаалаа амаар айлдан, зааж эхэлсэн бөгөөд борооны улиралд лам нар вихара буюу сүм хийдэд суун, Винай болон Судрын ёсыг судалдаг байсан сургалтын хэлбэр нь хожмын Буддын боловсролын төв, дацангийн үндэс болсон ажээ. Буддын үзэл санааны гол үндэс болсон гүн ухааны түүхэн хөгжлийн явцад Буддын дөрвөн үндсэн тогтсон таалал боловсорч, Наландар²⁵ (са: *nālandā*, тө: *na len dra*), Викрамаласила (са: *vikramaśilā*), Одантапури (са: *odantapuri*) зэрэг томоохон их сургуулиуд үүсэн хөгжиж тэдгээрт, “Буддын их таван ухаан” (са: *pañcavidyā*)-ы чиглэлийн дагуу мэтгэлцээний уламжлалд сургаж, олон зуун эрдэмтдийг төрүүлжээ.

Энэтхэгийн сургалтын энэ тогтолцоо Төвөдөд VII–XI зуунд нэвтэрч, дацангууд тодорхой сахилга бат, сургалтын шатлалтай болсон. Буддын шашин Монголд дэлгэрэхэд Төвөдийн энэхүү загвараар сүм хийдийн дэргэд гүн ухааны буюу цанид чойрын, тантрын, анагаах ухааны, зурхайн дацангуудтай сургуулийн тогтолцоо бүрэлджээ. Эдгээр дацан сургуульд лам нар олон жилийн шат дамжлагаар мэтгэлцээний аргазүйгээр суралцан, дамжаа барьж, эрдмийн зэрэг хүртэж ирсэн уламжлалтай.

Буддагаас 100 гаруй жилийн хойно Хутагтын орны төв “Очирт суурин”-аас хойд зүгт их хөлгөний ёсны таван зуун бандид (са: *pandita*) нар цугларч, Наландарын хийдийг үүсгэсэн нь Бурханы шашны төдийгүй дэлхийн анхны дээд боловсролын сургалтын байгууллага байжээ. Наландарын сургалтын хөтөлбөр нь хүнийг нийгэм, улс төр, ёс суртахууны бүхий л хэмжүүрийн дагуу оюун ухааныг хөгжүүлэх

²⁵ Бид төвөд дуудлагын орчуулгаар Наландар гэж хэрэглэж хэвшжээ.

зорилготой байсан (Krishna 2025: 173). Мөн сүм хийдийн сахилга бат, бясалгал, энэрэнгүй сэтгэл, даруу байх зэрэг чанаруудыг хөгжүүлэх ур чадварыг онолын эрдэмд суралцах зүтгэлтэй адил чухал гэж үздэг байсан нь суралцах чин эрмэлзэлтэй хүмүүсийг татах нэг шалтгаан нь байсан бололтой.

Цогт Наландараас олон мэргэд төрж, тэдгээрийн дотроос замбуутивийн зургаан чимэг, хоёр дээд гэж алдаршсан мэргэдийн бүтээлүүд Буддын шалгадаг ухааны тулгуур үндэс болсон (С.Гантөмөр 2010: 86).

Түүхэн сурвалжийн мэдээнээс үзэхэд 1600-аад оноос буддын сүм хийд байгуулагдан, хурал ном олноор гарсан ба ХҮП зууны дунд үеэс хойш цанид чойрын дацангууд цүглэж эхэлжээ. Монгол улсын түүх бичлэгт Монголд дэлгэрсэн Бурханы шашны түүхийг Зава Дамдин лам Лувсандаян (1864-1937) “Алтан дэвтэр” нэрт бүтээлдээ түүхэн сурвалж, эд өлгийн баримт дурсгал, мандан буурсан шалтгаан нөхцөлд үндэслэн гурав үечилж үзсэн (Лувсандаян 2014: 40)-ийг эрдэмтэн судлаачид баримталсаар ирсэн байна.

Бид Монголд үүсэж хөгжсөн учир шалтгааны ухааны түүхийг

1. Буддын цанид чойрын сургалтын суурь тавигдаж эхэлсэн үе (XVI -XVII зуун)
2. Буддын цанид чойрын сургалт дэлгэрэн хөгжсөн үе (XVIII-XX зууны эхэн үе)
3. Бурханы шашны дахин сэргэлтийн үе (1990-оноос эдүгээг хүртэлх үе) дэх чойрын сургалт хэмээн гурав хуваан үечилж үзэж байна.

Буддын цанид чойрын сургалтын суурь тавигдаж эхэлсэн үе (XVI -XVII зуун)

Түмэд аймгийн²⁶ “Алтан хан” Ананда²⁷ (1502-1581) 1578 онд өөрийн хатан, түшмэлийн хамт Содномжамц хутагт²⁸-тай “Тэгчинчойнхорлин” хийдэд учран золгосон нь шашны хожуу дэлгэрлийн эхийг тавьжээ. Энэ үед Халхын Автай сайн хан²⁹ “Цавчаал”-д хүрэлцэн очсоноор Халх Монголчуудын анхны хийд, Эрдэнэ зууг [1586 оны зун] байгуулах эхлэл болжээ. Автай сайн хан, дүү Түмэнхэний хамт, Гүмэн нансу ламыг залж, Тахай³⁰ нэрт балгадад Далай ламын дүрийг өөрөө бүтээж, гурван зуугийн сүм, шүтээн үлэмж байгуулсан (Банзрагч & Сайнтуяа 2004: 8) гэсэн нь халх Монгол дахь буддын шашны анхны хийдийн тухай баримт болно. Дармадалагийн “Хорчойнжун”-нд “Халх Түшээт хан аймгийн Эрдэнэзуу мянган шавьтай, дөрвөн дацантай Гоман игчааны цанид дацантай” (Дармадала 1995: 232) гэж тэмдэглэсэн.

²⁶ Түмэд аймаг нь зургаан түмний баруун гурван түмний нэг бөгөөд нөгөө хоёр түмэн нь Ордос, Юншиэбү болно. Баруун гурван түмэн нь Барсболд (1484-1531), Гүнбилэг жонон (1506-1550) болон ялангуяа Алтан хааны үед улам хүчирхэгжин нэр нөлөө нь ихэссэн байдаг. Алтан ханы улс төрийн дотоод, гадаад бодлогын далайц нь Монголчуудыг зарим талаар хяхан хавчиж байсан Мин улс (1368-1644)-ын бодлогыг цэргийн болон дипломат аргаар няцааж, хэвийн найрсаг харилцаатай, эрхшээлд автахгүй байхын үндэс нь гуравдагч улс орнуудтай харилцаж байх явдал гэж үзэж байжээ.

²⁷ Ананда буюу Алтан гэгээн хан нь баруун гурван түмний жонон цолтой захирагч бөгөөд Монголын бутралын үед цэргийн хүч чадлаар бусдаас давуу байсан тул өөрийн эрх мэдлээ нэмэгдүүлэхийн төлөө Мин улстай найрсаг харилцаж, Төвдийн Гэлүгвийн шашинд орж, уг шашны хүчээр Чингис хааны шууд угсааныхан нараас дутуугүй эрх мэдэлтэй болохыг чармайж байсан гэдэг.

²⁸ Эл уулзалтаар “Далай лам” цолтой болсон ба үүнээс хойшид гуравдугаар Далай гэж нэрлэгдсэн.

²⁹ Халхын Автай сайн хаан бол Чингис хааны 15-дугаар үеийн ач Батмөнх даян хааны 11 хөвүүний отгон Гэрсэнз Жалайр хунтайж хэмээн өргөмжилж, харьяат газраа суух ардыг 7 хөвгүүдэд 7 хувааж, зүүн ба баруун гарт захируулж, Зүүнгарыг захирсан нь түүний гуравдугаар хөвүүн Онохуй Үйзэн мөн тавдугаар хөвгүүн Амин Дураал бол Баруун гарыг захирсан нь түүний ахмад хөвгүүн Ашигай дархан хунтайж гэдэг. Онохуй Үйзэнгийн ахмад хүү бол Автай сайн хан агаад түүний хөвгүүн Совгоодой, Эрбээхий Мэргэн нар юм. Эрбээхий Мэргэний ахмад нь Түшээт хан Гомбодорж болно.

³⁰ Энэ нь 1229 оны орчим Өгөдэй хааны сууж байсан түүний хойно Тогоонтөмөр хааны сэлбэн шинэчилж нийслэл болгож байсан “Шарга азарга” хэмээх Шанхат уулын ар дахь хуучин балгас болно.

Энэтхэгээс Төвөд, Төвөдөөс Монголд уламжлагдсан учир шалтгааны ухааны хөгжил дэлгэрэлтэд анхдугаар Богд, Өндөр гэгээн Занабазар (са: *Jñānavajra*, 1635-1723) түүний шавь нар болох Ламын гэгээн Лувсанданзанчойжигжалцан (тө: *Blo bzang bstan-'dzin chos gyi rgyal mtshan*, 1639-1704), Заяын гэгээн Лувсанпэрэнлэй (тө: *Jaya-pandita blo-bzan-phrin-las* 1642-1715) нар чухал үүрэг гүйцэтгэв (Бира 2001: 195). Энэ тухай мөн Сүмбэ хамба бээр “Лувсанпэрэнлэйн Билхан нугын хийд 200 дотор зуурын дөрвөн дацан асан байшин, гэр хольцонгуй (Ишбалжир 2017: 616) хэмээсэн нь дөрвөн ухааны сургуультай байсныг тэмдэглэсэн хэрэг болно. Өндөр гэгээн хэд хэдэн хийдэд хурал номын үйлийг дэлгэрүүлэх, гүн ухаан чойрт сургахад анхаарч байсан тухай “Өндөр гэгээн 1647 онд Баруун хүрээ³¹-г үндэслээд Төвөд лам нарын хамт, шавилан суугчдад бурханы шашны их таван ухааныг заан сургаж байсан” (Пүрэвжав 1998: 47) гэжээ. Баруун хүрээ бол 1000 орчим лам нартай бөгөөд цанидын буюу гүн ухааны сургалтыг гоман игчааны дагуу явуулдаг том төв байсныг харж болно.

Мөн Өндөр гэгээн 1654 онд Хан Хэнтий ууланд “Буян дэлгэрсэн төгс баясгалант уулын номлол, бүтээлийн орон³²” (тө: *ribo dge rgyas dg'a ldan bshad sgrub gling*)-г анх үүсгэн байгуулсныг “Алтан дэвтэр”-т “Их хүрээнд түм гаруй хувраг суух ба Гандантэгчинлин, ар талд Гоман, Лосалин сургалттай хоёр их чойрын дацан болон бусад ухааны дацангууд, судар тантрын сургалтаараа ихэд алдаршсан” (Лувсандаян 2014: 197) гэснээс үзэхэд 10000 гаруй лам нар арван ухаан тэр дундаа гүн ухааны сургалтыг тасралтгүй явуулж байжээ.

Монгол орны бусад нутаг хошуунд байсан дацангийн талаар Хөвчийн бэйсийн хошууны Амарбаясгалан хийд, Үйзэн гүнгийн Чойен-одсаллин зэрэг томоохон хүрээ хийдүүд 1000-3000 ламтай, гүн ухааны сургалт явуулдаг Гоман, Лосалингийн хоёр дацантай, Цан бэйсийн хүрээ нь Сэра болон Гомангийн чойртой, Эрдэнэ-хамбын хүрээ, Баруун, Зүүн хошууны Гүнгийн хүрээ тус бүр Гоман игчаатай ба зөвхөн Гоман игчаатай сүм хийд 30 гаруйг, Сэра 20 орчим, Лолин³³ игчаатай 10-аад хүрээ хийдийг лам нарын тоотой тэмдэглэж, сүм хийд олон болой (Лувсандаян 2014: 262) гээд энд тойм төдий өгүүлсэн гэжээ.

Халх Монголд анх чойр гарсныг “Алтан дэвтэр”-т “Гоман дацангийн сургалттай, гүн ухааны дацан байгуулаад, 5 ботийн сургалтуудыг арвидуулан зохиосон тул эзэн, албат нийтээр хишиг буян нь дэлгэрчээ. Сэцэн ханы гүн ухааны дацан нь халхын чойрын анхдагч хэмээн алдаршсан” (Лувсандаян 2014: 252) гэсэн нь цагаан эргийн Гүндгаварлин хийд³⁴ юм. Хийдийг үүсгэн байгуулсан тухай Манжийн

³¹ Одоогийн Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг дахь Шанхын [уулын өвөрт байрлах] хийд юм. Анхдугаар Богдын сүүдэр гийсний (13-ны) ойд зориулсан бөгөөд Өндөр гэгээн ч өөрөө ихэд таалсан гэдэг. Хэлмэгдүүлэлтийн үед устгаж сүйтгэсэн хэдий ч үлдсэн Цогчэн дуганыг сэргээн эдүгээ хурал номын үйл ажиллагаа явуулж байна Өндөр гэгээнийг насан өндөр болох үед Түшээт хан Ванжилдорж, өөрийн хөвгүүн Пунцагравданг гэгээнд өргөсөнд Өндөр Гэгээн хөвгүүнийг “Ноён лам” хэмээн өргөмжлөн Баруун хүрээний шашны тэргүүнээр залсан байдаг.

³² Тус хийдийн туурийг 2015 онд ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн хийсэн малтлагаар XVII зууны үеийн Өндөр гэгээн Занабазарын үүсгэн байгуулж байсан Цагаан хотын туурь хэмээн тодорхойлж, голдоо том цогчин дугантай, түүнийгээ тойрсон барилга байгууламж бүхий хот байсан гэдгийг олж тогтоожээ. Дуган бүр өндөр довжооноос үүд рүүгээ хоёр талаараа буусан шаттай байсан ажээ. Их Хүрээний уламжлалт заншил ёсоор Хэнтий ханд суурин сүм хийд байгуулагдсан хөх морин жил буюу Сарьдагийн хийдийг байгуулсан 1654 оныг Их Хүрээ байгуулагдсан он гэж албан ёсоор тооцож тэмдэглэсээр ирсэн билээ.

³³ Лосалингийн игчааг ийн товчилдог.

³⁴ Хуучнаар Сэцэн хан аймгийн Сэцэн ханы хошууны нутагт орших Гүндгаварлин хийдийг Халхын Шолой Сэцэн хан (1577-1652)-ы санаачилгаар Хэрлэн мөрний хөвөөн дээр уужим талбиун хөндийд байгуулсан ба уг хийд нь 6 дацан, 4 аймаг, 10 дуган, 14 сүм суварга, 10 жастай, 520 ламтай (1930- оны

Эевэр засагчийн дансанд 1660 оны цагаан хулгана жил үүсгэсэн гэжээ. 1990 оноос Гүндгаварлин хийдийг сэргээн хурал номын үйл ажиллагааг явуулсаар байна. Ийнхүү цогчин болон бусад хурлууд, ухааны орныг судлах дацантай болсон нь учир шалтгааны ухаан хөгжих, түүнд суралцан мэргэшсэн олон эрдэмтэн лам нар төрөн гарахын эхлэл болжээ. Ингэж учир шалтгааны ухаан түгэн дэлгэрэх үндэс суурь тавигджээ.

Буддын цанид чойрын сургалт дэлгэрэн хөгжсөн үе (XVIII-XX зууны эхэн үе)

XVIII зуунаас Их хүрээнд монголчууд суурьшиж эхэлсэн шалтгааныг “Өргөө [хот]-д Монголын бүх өнцөг булан бүрээс лам нар цугларч Өргөө бол Монголын шашны төв болж хувирчээ” (А.Позднеев 1880: 6-9) гэсэн байна. Хүрээний лам нар тооны хувьд ямар байсан талаар “XIX зууны эхэнд 10000 орчим байсан ба 1915 он гэхэд 13754-д хүрсэн. XX зууны эхээр хичээл сургууль болон шүтээний гэсэн 12 дацанд 6000-10000 орчим лам нар Буддын шашны философи, анагаах ухаан, зурхай судалж байв” (Пүрэвжав 1961: 35) гэж тэмдэглэсэн.

Их хүрээнд чойр гарсныг “Дээрхийн уг эх”-эд “21 дүгээр онд³⁵ Хүрээний газарт цанид номын сургууль байгуулж, судар тарнийн шашныг ихэд бадруулж, хязгаарын олон амьтныг бурханы соёлоор жолоодож, гайхамшигт эрдэм дөрвөн этгээдэд нэвтэртэл дуурьсгаж шашны итгэл болов” (Батсайхан & Лонжид 2019а: 21) гэсэн нь 1756 онд хоёрдугаар Гоман (тө: *sgo mang*) хэмээгдэх Их хүрээний гүн ухааны Дашчоймпэл (тө: *bkra shis chos 'phel grwa tshang*) дацанг II Богд Жавзандамба болон Манзушир хутагт хамтран үүсгэн байгуулсныг өгүүлсэн хэрэг юм. Сүмбэ хамбын тэмдэглэснээс “Халхын зүгт Даранат Жавзандамбын дээд төрөл Лувсандамбийжалцан байгуулсан хуучин хийд 300 хийгээд хойт Лувсандамбийдонмэгийн барьсан шинэ хийд Галданшадавдаржаалин 4000 гэр хийдэд манагаар ухааны орны сургууль сайн (Ишбалжир 2017: 616) гэсэн нь дацангийн сургалт алдартай байсныг гэрчилнэ. Дашчоймпэл дацан бол 6000 гаруй ламтай Их Хүрээний сургалтын гол төв байжээ (Сонинбаяр 1995: 65).

IV Богд Жавзандамба Лувсангэлэграважаа Их хүрээнд 1809 онд Гунгаачойлин дацан (тө: *kun dga 'chos gling grwa tshang*)-г Банчин игчааны дагуу байгуулсан байна. Анхны энэ хоёр дацангаас чойрын гүн ухаан болон бусад ухаанд нэвтэрсэн олон мэргэд төрөн гарсан юм. V Богдын Лувсанчүлтэмийн шашин ном, учир шалтгааны ухааны түүхэнд холбогдох баримтыг “Жавзандамба хутагтын өлмий бататгах, бурхны номыг нэн хөгжүүлэхийг хичээж, Хүрээний зүүн этгээдэд цанид номын зэрэг таван анги хурлын дуганыг салган байгуулж Гандантэгчэнлин гэж нэрийдсэн” (Батсайхан & Лонжид 2019b: 16). Энэ үеэс Их хүрээний бүх лам нарыг албан ёсоор цанид чойрын дацанд суралцуулдаг журам тогтсон нь шашин нэн дэлгэр хөгжихөд гол нөлөө үзүүлжээ. Улмаар V Богд Жавзандамбын үед дээрх хоёр дацангийн шавь нар олширч,

байдлаар) байсан гэдэг. Тэдгээр дацангууд нь Түвдэнжунай шадувчойпэллин хэмээх Чойрын, Гүндгаварлин хэмээх Цогчин, Санагдэчинчойнхорлин хэмээх Жүдийн, Эвамдашийпунцоглин хэмээх Дүйнхорын, Шампансойригшадувдаржаалин хэмээх Мамбын, Гунгаасамданпэлжээлин хэмээх ёгийн гэсэн нэртэй байсан ба Зүүн өмнөд зүгт Пунцогдэжидлэн, Баруун өмнө зүгт Гэндүнпэлжээлин, Баруун хойд зүгт Шадувдаржаалин, зүүн хойд зүгт Пунцогхамцанлин аймгуудтай 10 дуганаас гадна Мянган бурхны болон Хангалын гэсэн 2 дугантай байжээ. Гүндгаварлин хийдийн барилга байгууламж нь 1958 он хүртэл бүрэн бүтэн байсан гэдэг. Эл хийдэд Халхад анхны чойр бий болж үүнээс 7 жилийн дараа Их хүрээнд чойртой болсон аман түүх бий. Одоогийн Хэнтий аймгийн төв “Хийдийн суурин” хэмээх газар Хэрлэн голын хөвөөнөө байрлаж байна.

³⁵ Тэнгэрийн тэтгэсний хорин нэгдүгээр он нь аргын 1756 он болно.

хичээл сургалт сайжран олон эрдэмтэн төрөн гарч Монголын соёл, сэтгэлгээний түүхэнд үлэмж ач холбогдол бүхий олон боть зохиол Төвөд хэлээр зохиожээ.

VIII дүрийн Богд Жавзандамба хутагт Агваанлуvsан (тө: *ngag dbang blo bzang chos kyi nya ma bdan bzang dban phyug*, 1869-1924) 1911 онд Монгол улсын хаанаар өргөмжлөгдсөн (Дамдинсүрэн 1959: 9) нь шашин-төрийн үйл хэргийг хослон явуулахын зэрэгцээ гүн ухааны сургалт, дацан сургуулийн үйл ажиллагаанд ихээхэн дэмжлэг болжээ. Богд бээр өөрөө дамжаа барьсан тухай “Богд Агваанлуvsан нь ямар ч ном зохиолыг цээжлэн, бясалгадаг. Дамжаанд бэлдэж тус бүр 700-аад хуудас бүхий таван ботийн дайтай ном цээжилсэн ба 1908 оны зуны дунд сард Гунгаадаржаалин³⁶ дацанд гавжийн дамжаа барьжээ. Өмнөх дүрүүд дамжаа барьж байсангүй” (Банзрагч & Сайнхүү 2004: 20) гэж тэмдэглэжээ.

Богдын зарлигаар Жанрайсиг бурханыг бүтээсэн ба Хүрээ барын Ганжуурыг хэвд гаргаж, түмэн гэлэнгийн хайлан хуруулж, 1910 онд Сэржэвзүнбийн игчаа (тө: *sera yig cha*)-г судлах Идгаачойнзэнлин (тө: *yid dga' chos dzin gling grwa tshang*) дацанг байгуулжээ. Ийнхүү чойрын гурван их дацан болон бусад ухааны дацантай болсон нь учир шалтгааны ухаан хөгжих, түүнд суралцан мэргэшсэн олон эрдэмтэн лам төрөн гарахын эхлэл болжээ.

XIX-XX зууны эхэн үед Монголын шашин соёлын гол төв болох Гандан³⁷-д цанид, чойрын гүн ухаан судлах дацангуудад олон зуун лам суралцаж, Зүүн хүрээнд гучин аймаг³⁸, түүний удирдлага төвлөрч хурал ном, шашны зан үйлийг эрхэлдэг байв. Их хүрээний эрдэм зэрэгтэй лам нарын тоог гаргахад 800-900 шахам гавж мөн түүнчлэн 150-200 орчим лхаарамба байсан нь бурхан шашны хөгжил тэр төдийгүй гүн ухааны сургалт эрчимтэй явагдаж байсныг харуулах бас нэгэн баримт болно. Монголын энэ гурван дацан болон бусад нутаг хошууны сургуульд боловсорсон эрдэмтэн лам нар өөрсдийн аргазүйг боловсруулж байсан энэ үеийг бид Гэлүгвийн ёс зонхилохын зэрэгцээ Буддын цанид чойрын сургалт төлөвшиж, нэн дэлгэр хөгжсөн үе гэж үзэж байгаа юм.

Бурхны шашны дахин сэргэлтийн үе (1990-оноос эдүгээг хүртэлх үе).

1990-ээд оноос Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай, социалист нийгэм, улс төрийн тогтолцооноос зах зээлийн чөлөөт эдийн засагтай, ардчилсан нийгэмд шилжсэнээр нийгмийн амьдралын бүх хүрээ, түүний дотор манай нийгмийн оюун санааны амьдралд суурь өөрчлөлтүүд гарсан юм. 1992 онд баталсан шинэ Үндсэн хуульд иргэдийн шүтэн бишрэх эрх чөлөөг хуульчилж, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 2.4.1 -т “Төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ” гэж заасан³⁹. Улмаар ард иргэдийн шүтэх эрх сэргэж, сүм хийд, дацан сургуулийг сэргээн байгуулж, хутагт хувилгаан тодруулах, Бурхны номд суралцах, бусад орноос эрдэмтэй лам нарыг залах, номын лүн (тө: *lung*), ван (тө: *bang*) хүртэх, Бурхны шашны судар (тө: *mdo*), шастир (тө: *bstan bcos*)-ыг орчуулах, судлах, хэвлэн нийтлэх нь нэмэгдэж буй нь шашин дахин сэргэсэн үйл явц гэж үзэж болох юм.

Дүгнэлт Энэтхэгт үүссэн Наландрын уламжлал төвөдөөр дамжин монголд дэлгэрсэн түүхэн үйл явцын логикийг гаргахын тулд энэхүү үйл явц дахь нөлөө бүхий

³⁶ Энд ингэж тэмдэглэсэн ч зарим судлаачид Гунгаачойлин дацанд дамжаа барьсан гэж үздэг.

³⁷ Ганданг V Богдоос Бурхны шашны гол төв болгох зорилгоор Далхын дэнж хэмээх газар байгуулжээ.

³⁸ Өндөр Гэгээн анх 1651 онд Сангай, Зоогой, Ноёны, Дархан эмч, Өрлүүд, Амдуу, Жасын гэсэн долоон аймгийг байгуулсанд тоо нь өссөөр XIX зууны эхэнд хамгийн сүүлийн аймаг байгуулагдаж Хүрээ гучин аймаг, 10 дацантай хэмээн түүхэнд тэмдэглэгджээ.

³⁹ <https://legalinfor.mn/mn/detail/485> (2023.01.25)

үйл явдлуудыг түүхэн сурвалжаас тодруулсан. Бурхны шашны дотоод тогтсон таалал, буддын их таван ухаан түүний дотор учир шалтгааны ухаан боловсорч хөгжихөд эртний энэтхэгт үүссэн Наланда, Викрамаласила, Одантапури зэрэг томоохон их сургуулиуд, тэдгээрийн сургалтын хөтөлбөр, ялангуяа мэтгэлцээний аргазүй чухал нөлөө үзүүлсэн гэж үзэх боломжтой. Буддын цанид чойрын сургалт дэлгэрэн хөгжсөн үед шашин дэлгэрэх түүхийн явцад сүм хийдийн дэргэд цанид чойрын дацангууд байгуулагдаж, тэдгээрийн сургалтын хөтөлбөр, хэлбэршин төлөвшин тогтжээ. 1980-аад оны сүүлчээс эхэлсэн Монгол дахь Бурхны шашны дахин сэргэлт нь далан жил дарагдсаны дараа бурхны шашин соёлын төдийгүй сэтгэлгээний үнэт өв байсныг харуулах олон баримтууд илэрсээр байна. Дахин сэргэж буй Бурхны шашны уламжлалт мэдлэг ухаан нь өнөөгийн монголчуудын хувьд бурхны шашнаар дамжсан ёс суртахууны харилцаа, зан үйлийг сэргээх нүүдлийн соёл иргэншлийн хэв шинж, үндэсний онцлогийг шинэчлэхтэй холбогдож байгаа гэж үзэж болох юм.

Ном зүй

- Банзрагч, Ч & Сайнтуяа, Ц. 2004. VIII дүрийн Богд Жавзандамба хутагтын анхны лүндэн түүх, угсаатан судлалын сурвалж бичиг болох нь. УБ.
- Банзрагч, Ч & Сайнхүү, Б. 2004. Монголын хүрээ хийдийн түүх. Монгол улсын үндэсний төв архивын данс. УБ.
- Бира, Ш. 2001. Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа: Монгол дахь буддын шашны түүхчилсэн товч тойм. Боть Ш. Интерпресс, УБ.
- Гантөмөр, С. 2010. Буддын гүн ухааны уламжлалт сургалтын онцлог ялгамжаа. Д.Онолтбаатар (эмх) Дүлтим Зансүрэн Идгаачойнзинлин дацангийн түүх. 86-94. ЭМШУИС-ийн “Эрхэс” хэвлэх үйлдвэр. УБ.
- Дармадала. 2014. Их Монголын оронд дээдийн ном хэрхэн дэлгэрсэн түүх (орч: Номч мэргэн гавж С.Гомбожав). Гандантэгчинлин хийд, УБ.
- Лувсандаян (Зава Дамдин). 2014. Гантөмөр, С. (Орч). Их Монгол оронд бурхан шашин дэлгэрсэн түүх Алтан дэвтэр. УБ.
- Пүрэвжав, С. 1998. Монгол дахь шарын шашны хураангуй түүх (XVI-XVIII зууны эхэн). УБ. Сүхбаатарын нэрэмжит хэвлэлийн комбинат. х. 287.
- Krishna, Ajay. 2025. Beyond the Monastic Walls: An Analysis of Pedagogical Methods, Curricular Diversity, and Socio-Political Influence in Ancient Nalanda’s Educational System. *Amoghvarta*. Vol-05. 172-177.
- Sechin, Jagchid. 1997. A retrospective look at Mongol-India historical relations. In R.C. Sharma (Ed): *Mongolia: Tryst with change and Development*. XXX. Patiala, New Delhi.

On the periodization of the emergence and development of Tsanid and Choir education in Mongolia

Keyword: *Mongolian philosophy, tsanid, choir, monastic debate, Nālandā, Na len dra.*

In the history of Mongolia, Buddhism spread on three occasions: during the later dissemination, it reached a high level of development and gave rise to the designation “Mongolian Buddhism,” which is inseparably connected with the emergence and development of “Buddhist logic,” one of the Five Great Sciences of Buddhism. Under the

designation “Buddhist logic”, Indian scholars elaborated on influential theories in fields such as philosophy, psychology, and logic–epistemology. Within the framework of the theories established by these thinkers, Tibetan scholars developed a framework of analytical debate. On the basis of this methodology, Mongolian scholars investigated the profound understandings and problems of Buddhist philosophy from all different vantage points and produced numerous treatises and collected works, which constitutes one piece of evidence for the extensive flourishing of Buddhist logic. Up to the present day, this has remained a component of the educational structure of Tibetan and Mongolian tshanid and choir schools and is one of the keys to understanding Buddhist philosophy. Although a considerable number of scholars have periodized the history of Buddhism in Mongolia, studies that specifically examine the history of tsanid and choir schools are rare. The present study suggests a periodization based on evidence from historical sources.